

АНУ ба түүний хань хамсаатны түрэмгийлэл, цөмийн зэвсгээр хөөцөлддөг бодлогыг даян дэлхийн олон миллиард хүмүүс газар сайгүй эсэргүүцэж, зөвлөлтийн энх тайванч бодлогыг тууштай дэмжиж байна.

Энх тайвны энэ их тулалдааны тэргүүн эгнээнд Октябрийн хувьсгалын эх орон - ЗХУ, социалист хамтын нөхөрлөлийн бусад орнууд, олон улсын коммунист ажилчны хөдөлгөөн явж байна. Энэ тэмцэлд нам, төрийнхээ энх тайванч бодлогыг сайшаан дэмжиж байдаг монголын ард түмэн, манай олон нийт мөн идэвхтэй оролцож байгаа юм. Дайны эсрэг, энх тайвны төлөө өргөн олон түмний тэмцэл идэвхжиж буй нь Аугаа их Октябрийн үзэл санааны шинэ яруу тод илрэл мөн.

ЭНЭТХЭГ УЛСЫН ЭНХ ТАЙВАН, ДЭВШИЛ ХӨГЖЛИЙН 40 ЖИЛ

Д. Пүрэв

Энэтхэг орныг манай ард түмэн эрт дээр үеэс сайн мэддэг бөгөөд түүх соёлын мянган жилийн гайхамшигт уламжлалыг нь хүндэтгэж иржээ.

Өнөөдөр Энэтхэгийн 328 сая ам дөрвөлжин км нутагт 750 сая¹ хүн ам оршин сууж байна. Энэтхэг орон бол Азийн эртний түүхт олон үндэстэн, ястны өлгий нутаг, хүн төрөлхтний соёл, иргэншлийн томхон төв юм. Одоогоос 3000 гаруй жилийн тэртээд үндэс суурь нь тавигдсан Энэтхэгийн соёл иргэншил хүн төрөлхтний түүх соёлд арилшгүй тод ул мөрөө үлдээжээ. Энэтхэгийн ард түмэн түүхэн урт удаан хөгжлийнхөө явцад эдийн болоод оюуны соёлын асар их баялагийг бүтээсэн төдийгүй, өөрийн соёлоороо бусдыг өөртөө татах их хүчийг бий болгожээ. Энэтхэгийн соёл, урлагийн бас нэг онцлог нь харийн ард түмний соёлын өв уламжлалын аль үнэ цэнэтэйг өөртөө шингээж авахдаа өвөрмөц шинж төрхөө ямагт хадгалан үлдэж байсан явдал юм. Түүхийн хөгжлийн бүр эхэн үеэс уламжлагдаж ирсэн Энэтхэгийн соёлын төвүүд нь Инд, Ганга мөрний сав, Маханади, Годавари, Кришна, Өмнөд Энэтхэгийн Кавари зэрэгт байдаг бөгөөд энд оршин суугчид эрт дээр үеэс аж ахуйгаа эрхлэн явуулах онцгой хэвшил, арга барилтай байсан төдийгүй Хинду шашны сургаал номлолд тулгуурласан нийгмийн институттай байжээ.²

XVIII зуунд Энэтхэгт ноёрхолоо тогтоосон Британий колонийн дэглэх Энэтхэгийн нийгэм, түүх, соёлын хөгжлийг хойш татах болов. Британийн колоничлогчид Энэтхэгт зөвхөн улс төрийн ноёрхолоо тогтоосон төдийгүй, колоничлогчдын техникийн «Шинэ соёл» нь энэтхэгчүүдийн олон үеийн амьдралын уламжлалт хэвшлийг эвдэж, феодалын нийгмийн эдийн засгийн бүтэц (хөдөө аж ахуй, үйлдвэр-гар урлал, худалдаа, уран сайхны урлал) -ийн үндсийг бусниулжээ. Засаг захиргаа, нийгмийн байгууламжийн уламжлалт бүтэц колонийн эзэнт

1 «За рубежом» No 4, 1987.

2 Страны и Народы (Южная Азия) «Мысль» 1982. с. 31–33.

гүрний дарангуйллын аппаратаар солигдож колониололын дэг журамд шилжжээ.

Октябрийн социалист хувьсгалын 70 жилийн ойн босгон дээр Энэтхэгийн ард түмэн тусгаар тогтнолынхоо 40 жилийн ойг тэмдэглэж байгаа нь учир холбогдолтой юм. Энэ хоёр үйл явдал түүхэн цаг үеийн гүн гүнзгий уялдаа холбоотой билээ.

Орос оронд ялсан Октябрийн хувьсгал Британийн колонилогчдын эсрэг Энэтхэгийн ард түмний үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэлд гүн гүнзгий нөлөө үзүүлж уг тэмцлийг шинэ шатанд гаргасан юм. Хэдийгээр Орос оронд болж байсан хувьсгалт үйл явцыг Британийн колонийн засаг захиргаа Энэтхэгийн олон нийтээс нуун далдлахыг элдвээр оролдож байсан боловч Октябрийн үзэл санаа Энэтхэгийн ард түмэн, үндэсний чөлөөлөх хөдөлгөөний удирдагчдын дунд өргөн дэлгэрч, харийн булаан эзлэгчдийн эсрэг тэдний тэмцэлд эрч хүч нэмж, улс төрийн ухамсарт нь ихээхэн нөлөөлсөн юм.

Ялангуяа пролетарийн хувьсгалын их удирдагч В. И. Лениний идэвхтэй оролцоотойгоор бүх нийтэд зарлан тунхагласан энх тайвны тухай, газрын тухай тунхаглалууд Британийн дарлалд байсан Энэтхэгийн сая сая ажилчин, тариачин, сэхээтний өргөн давхрагын харийн булаан эзлэгчдийн эсрэг хийх тэмцлийг шинэ утга агуулгаар баяжуулжээ. Октябрийн хувьсгалын нөлөөн дор эрх чөлөө тусгаар тогтнолынхоо төлөө тэмцэж байсан Энэтхэгийн ард түмэн үндэсний чөлөөлөх тэмцлээ нийгэм-эдийн засгийн бие даасан байдлаа хангах, гуйланчлал, ядуу зүдүү, эрх чөлөөгүй байдлаас ангижрахын төлөө тэмцэлтэй уялдуулан холбохын зайлшгүй чухлыг гүнээ ухамсарлаж эхэлсэн байна. XIX зууны 20-оод онд Энэтхэгийн коммунист нам байгуулагдаж империализм, колониололын эсрэг Энэтхэгийн хөдөлмөрчдийн зохион байгуулалттай тэмцлийг удирдах болсон явдал нь Бүх Энэтхэгийн үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний нэг бүрэлдэхүүн хэсэг нь болж чадлаа.

В.И. Ленин үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг империализмын эсрэг явуулах тэмцлийн шийдвэрлэх хүчин зүйл хэмээн үзэж байсны нэгэн адил Энэтхэгийн ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний удирдагчид Махатма Ганди, Жавахарлал Неру нар Зөвлөлт Орос улсыг өөрийн үндэсний чөлөөлөх тэмцлийн найдвартай түшиг тулгуур хэмээн үзэж Орос оронд болж байсан түүхэн үйл явдалд онцгой ач холбогдол өгч байв. Ж. Неру: «Зөвлөлтийн (Октябрийн) хувьсгал хүн төрөлхтний нийгмийг урагш нь ихээхэн ахиулсан унтрааж болшгүй хурц гал дөлийг асаасан юм. Тэр нь (хувьсгал) дэлхий дахин тэмүүлж болох шинэ соёл иргэншлийн суурийг тавьсанд би эргэлзэхгүй байна»³ гэж Октябрийн хувьсгалын олон улсын ач холбогдлыг үнэлж хэлжээ. Мөн тэрээр 1936 онд хуралдсан Энэтхэгийн үндэсний конгресс намын их хурал дээр үг хэлэхдээ: «...Зөвлөлт Орос улс оршин тогтнож, их зүйлийг хийж бүтээж байгаа нь бидний ирээдүйг улам итгэл найдвартай болгож байна.

Зөвлөлт Оросын маягийн шинэ соёл иргэншил бусад улс гүрэнд дэлгэрч, империализмын бодлогоос үүдэн бий болсон дайн самуун, зэвсэгт мөргөлдөөнийг эцэс болгоно гэдэгт бид итгэж байна»⁴ гэжээ. Дэлхийн II дайны эцсээр өрнөсөн Энэтхэгийн ард түмний үндэсний

3 А. В. Горев, Махатма Ганди. Москва, 1984, с. 68.

4 П. В. Куцобин «Ленин и Индия», «Индия» 1980 «Ежегодник» с. 15.

эрх чөлөөний төлөө тэмцлийн эрчимтэй өрнөлтийн үр дүнд Английн колоничлогчдыг эх орноосоо хөөн гаргаж 1947 оны 8-р сарын 15-нд Делийн «Улаан цайз» хэмээх түүхт газарт Энэтхэгийн олон үндэстэн ястны эрх чөлөөний билэг тэмдэг болсон төрийн гурван өнгөт далбааг ёслол төгөлдөр өргөн мандуулснаар тусгаар тогтносон, бүрэн эрхт, эхийг эрхэмлэгч Энэтхэг улсын үндэсний сэргэн мандалтын шинэ үе эхлэв.

Энэтхэгийн ард түмэн Британийн 200 жилийн дарлалаас ангижрахдаа өлсгөлөн гуйланчлал, өвчин эмгэгт нэрвэгдсэн, эрэмдэг, зэрэмдэг аж ахуйтай Энэтхэг орныг хүлээж авсан юм. Тэр үед Колонийн Дархалыг таягдан хаясан улс орнууд нийгмийн хөгжлийн янз бүрийн зарыг сонгон авч байв. Энэтхэгийн хувьд гэвэл юуны өмнө эдийн засгаа биеэ даасан байдлыг хангах замаар олон зуун жилийн хоцрогдлоос ангижирч, улс төрийн тусгаар тогтнолоо бэхжүүлэх, Энэтхэгийн эдийн засаг нийгмийн хөгжлийн гадаад энх тайван нөхцлийг бүрдүүлэхийн тулд энх тайвнаар зэрэгцэн орших «Панча шила»-ийн зарчимд үндэслэсэн эвсэлд үл нэгдэх гадаад бодлогыг явуулах чиг шугамыг сонгон авчээ.

Орчин үеийн шинжлэх ухаан техникийн хувьсгалын ололт амжилтаа тулгуурлан Энэтхэгийн аж үйлдвэрийн гол салбар хүнд үйлдвэрийн үндэс суурийг бэхжүүлж хөгжүүлэх явдал Энэтхэг улсын эдийн засгийн бодлогын тэргүүн зэргийн зорилтын нэг байв. Тусгаар тогтнолын жилүүдэд Энэтхэгийн хүнд үйлдвэрийн салбар түргэн хурдацтайгаар хөгжиж эдийн засагт зонхилох байр эзлэх болов. Ж. Неругийн хэлсэнчилэн «Шинэ Энэтхэгийн сүм дуганууд» Энэтхэгийн өнцөг булан бүрт сүндэрлэн босч улс орны амьдралын зүрх судас нь болов. Бхилай Бокарогийн хар төмөрлөгийн комбинатууд, Хардвар, Ранчи, Дургаиурын машины үйлдвэрүүд, Корба дахь хөнгөн цагааны үйлдвэр, Койяли болон Барауни дахь нефть боловсруулах завод, бусад олон арван үйлдвэр аж ахуйн барилга байгууламжууд баригджээ. Энэтхэг улсын эдийн засгийн биеэ даасан байдлыг бэхжүүлэхэд ЗХУ, Социалист нөхөрлөлийн орнууд чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Зөвхөн ЗХУ-ын техник-эдийн засгийн тусламжтайгаар байгуулагдсан үйлдвэрүүд өнөөдөр ган хайлуулалтын 40 гаруй, нефть гаргалтын 60 нефть боловсруулалтын 30, эрчим хүчний 20 гаруй хувийг тус тус гаргаж байна.⁵ Өнгөрсөн 30 гаруй жилийн хугацаанд ЗХУ-ын оролцоотойгоор 60 гаруй үйлдвэр, барилга байгууламжийг тоноглож 40 гаруйг барьж байгуулжээ. Жилд 12 сая тонн ган гаргах Висакхапат Елена хар төмөрлөгийн комбинатыг өнөөдөр Энэтхэг, Зөвлөлт хамтдаа барьж байна. ЗХУ. Энэтхэг, хоёр хавсарга болон суурь судалгааны 22 чиглэлээр, мөн Шинжлэх ухаан технологи, үйлдвэрлэлийн хоршооллын салбарт амжилттай хамтран ажиллаж байгаа юм.⁶ Мөн социалист орнууд Энэтхэгийн үндэсний аж үйлдвэрийн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, зураг төсөл зохион бүтээхэд тусламж үзүүлж байна. Энэтхэгийн улс ардын аж ахуйн дэвшил хөгжил, эдийн засгийн биеэ даасан байдлыг бэхжүүлэх, орчин үеийн хүнд аж үйлдвэрийн үндсийг бий болгоход улсын сектор өнөөдөр ч чухал үүрэг гүйцэтгэж байна.

Улсын секторын хүрээнд 300 гаруй үйлдвэр, аж ахуйн байгууллага багтаж байгаа бөгөөд үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 40 гаруй

5 «Международная жизнь» № 8. 1986. С. 20

6 «За рубежом» № 4. 1987.

хувийг тэр гаргаж байгаа юм. 80-аад оны эхэнд энэ салбар нүүрс гаргалтын 98, цахилгаан эрчим хүчний 80 гаруй, нефть боловсруулалтын 90—100 ган хайлуулалтын 80, суурь машин, азотын бордоо үйлдвэрлэлтийн 50—60 хувийг гаргаж, уул уурхайн үйлдвэрүүдийн бүтээгдэхүүн, банк, даатгалын компаниудын 70 гаруй хувь нь мөн улсын секторт хамаарагдаж байна. «Улсын сектор орчин үеийн технологийн процессыг бий болгож эзэмшихэд тэргүүлэгч үүрэг гүйцэтгэж манай эдийн засгийн тусгаар тогтнол, бие даасан байдлын үндэс болов. Бид энэ салбарыг цаашид бэхжүүлж, үйл ажиллагааг нь сайжруулах болно»⁷ гэж Ерөнхий сайд Р. Ганди энэ салбарын ач холбогдлыг үнэлжээ. Гэвч өнөөдөр Энэтхэгийн эдийн засагт хувийн капиталист сектор зонхилох байр эзэлсэн хэвээр байж үндэсний монополи түргэн өсч байна. Энэтхэгийн 130 гаруй томоохон монополист гурпп хувь нийлүүлсэн компанийн нийт активын 70 гаруй хувийг эзэмшиж гадаадын капиталын хувийн жин өсч, аж үйлдвэр дэх гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ 20 гаруй миллиард рупийд хүрээд байна. Үүний зэрэгцээ тив хальсан корпорацаар дамжин гадаадад 10 млрд орчим рупии гарч байгаа нь улс орны эдийн засгийг улам ээдрээ түвэгтэй болгож байгаа юм.

Тусгаар тогтнолын жилүүдэд усжуулах байгууламжийг өргөтгөж, хөдөө аж ахуйд оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн, газрын шинэчлэлийн бодлогыг явуулж, агротехникийн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсний үр дүнд хүн амын 70 гаруй хувь нь оршин суудаг хөдөө тосгоны аж байдал мэдэгдэхүйц сайжирлаа. Одоо Энэтхэгийн тариалангийн талбайд 360 мянган трактор, 3 сая гаруй цахилгаан шахуурга ажиллаж, хөдөө тосгоныг цахилгаанжуулах төлөвлөгөө амжилттай хэрэгжиж байна. Энэтхэг 1985—1986 онд 150 сая тонн үр тариа хураан авсан нь дотоодын хэрэгцээг бүрэн хангаад зогсохгүй улмаар Энэтхэгийн үр тарианы нөөцийг ихээхэн нэмэгдүүлжээ. Одоо Энэтхэг 30 сая гаруй тонн үр тарианы нөөцтэй байна. 1986—1987 оны санхүүгийн жилд 160 сая тонн үр тариа, 14,8 сая тонн тослог ургамал, 8,8 сая кип хөвөн, 8,5 сая кип олсны ургамал, 190 сая тонн сахарын нишинг хурааж авахаар төлөвлөжээ.⁸

Энэтхэгийн улс ардын аж ахуйн гол гол салбарыг төлөвлөгөөтэйгээр хөгжүүлэх бодлогыг 1951 оноос эхлэн хэрэгжүүлж ирсний үр дүнд зөвхөн аж үйлдвэр, хөдөө аж ахуйн салбарт төдийгүй шинжлэх ухаан, техник, бүх нийтийн боловсрол, соёл урлагийн талаар Энэтхэг улс дорвитой амжилтанд хүрчээ. Шинжлэх ухаан техникийн салбарт ажиллаж байгаа мэргэжилтнийхээ тоогоор Энэтхэг улс ЗХУ, АНУ-ын дараа 3-р байранд орж 2 сая гаруй мэргэжилтэнтэй болжээ. Энэтхэгийн үндэсний нийт бүтээгдэхүүний бараг 1,5 хувийг шинжлэх ухааны судлалд зарцуулж сансар, далай тэнгисийн амьдрал, антаркти судлалаар их амжилт олжээ. Цөмийн энергийг энх тайвны зорилгоор судалж 2000 мегаватын хүчин чадалтай атомын 10 реактор-хурдасгагчийг барьж байгуулаад одоо Энэтхэг улс цөмийн эрчим хүчний үндэсний программын 2 дахь үе шатандаа⁹ шилжин ороод байна. Халуун орны элдэв өвчнийг судлахад изотопыг өргөн ашиглаж байна. Ойрын жилүүдэд Энэтхэгийн атомын цахил гаан станцуудын хүчин чадлыг 10 мянган мегатоннд хүргэхээр төлөв -

7 «Файнэшл Таймс» Лондон, 1986.

8 «За рубежом» № 4 1987

9 «Новое время» № 8 1987

лөж байна. Ийнхүү шинжлэх ухаан техникийг хөгжүүлэхэд онцгой анхаарч байгаа нь орчин үеийн Энэтхэг улсын хөгжил дэвшлийн нэг чухал хүчин зүйл болж байгаа юм.

Тусгаар тогтнолын жилүүдэд Энэтхэг улс боловсролын салбарт их амжилт олжээ. 40 жилд суралцагчдын тоо 4 дахин өсөв, орон даяар бүх нийтийг анхан шатны боловсролтой болгох зорилт хэрэгжиж байна. 1947 онд хүн амын зөвхөн 10 орчим хувь нь бичиг үсэгтэй байсан бол 80-аад оны эхэнд 36 хувь нь бичиг үсэгтэй болжээ. Одоо Энэтхэгийн 130 гаруй их, дээд сургуульд 2,7 сая оюутан суралцаж байна.

Хүн ам, өргөн уудам нутаг дэвсгэр, түүх соёлын эртний өв уламжлалаараа Азид төдийгүй, дэлхийн том гүрэн болох Энэтхэг улсын олон улсын байр суурь тусгаар тогтнолын жилүүдэд ихээхэн бэхжиж, нэр хүнд нь өслөө. Энэтхэг улс эвсэлд үл нэгдэх зарчимд бат тулгуурласан энх тайванч бодлогыг гадаад улс орнуудтай явуулах харилцаандаа тууштай хэрэгжүүлж энх тайвнаар зэрэгцэн орших «Панча Шила»-г хөрш зэргэлдээ улсуудтайгаа харилцах харилцаандаа амжилттай хэрэгжүүлж империализм, колоницлол, шинэ колоницлолын бодлогын эсрэг шинэ тулгар тусгаар тогтносон улсуудын хамтын тэмцлийн үндэс суурийг тавьсан Бандунгийн түүхт үзэл санааг боловсруулахад чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Орчин үеийн олон улсын харилцааны нөлөө бүхий хүчин болж эгнээндээ 100 гаруй орныг багтаасан эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний үндсийг тавилцаж зохион байгуулалтын талаар бэхжүүлэн түүний империализм колоницлол, шинэ колоницлол, апартеид бодлогын эсрэг байр суурийг бататгахад Энэтхэг улсын оруулсан хувь нэмэр асар их юм. Энэтхэг болон эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний гишүүн зургаан улс цөмийн зэвсгийг туршихыг хориглох, устгахтай холбогдуулан оновчтой санал гаргаж,¹⁰ цөмийн эсрэг зарчмын үндсийг тавьсан «цөмийн зэвсэггүй, хүчирхийлэлгүй дэлхий ертөнцийг байгуулах тухай» Делийн тунхаглалд Энэтхэг Зөвлөлтийн удирдагчид гарын үсэг зурсан юм.

Нийгмийн өөр өөр байгууламжтай улсуудын хооронд энх тайвнаар зэрэгцэн орших «Панча Шила»-д тулгуурласан, найрамдалт харилцаа үр ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн Монгол, Энэтхэгийн уламжлалт найрамдалт харилцаа өнөөдөр амжилттай хөгжиж байгаа нь тус хоёр ард түмний язгуур эрх ашигт бүрэн нийцэж байгаа төдийгүй улс түмний энх тайван оршин тогтнож аж төрөх эрхийг хангах, харилцан ойлголцох хамтран ажиллах үзэл санааг хэрэгжүүлэх Ази тивийн өргөн уудам бүс нутагт аюулгүй байдлын иж бүрэн систем бий болгох бүх нийтийн хүчин чармайлтад тус дөхөм болж байгаа юм.